



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/05/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 99019800

цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 төлбөрийн акт	18
5. 2 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ ТАНАА

2023.02.10 № 2/85
танай _____-ны № _____-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт Мэргэжлийн боловсрол сургалт үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвөөс 2022 оны 4 сард LAND 100 маркийн автомашиныг шилжүүлсэн бөгөөд 2022 оны 11 дүгээр сард албаны ажлаар явж байгаад осолд орсны улмаас цаашид ашиглах боломжгүй болсон байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор дээд шатны байгууллагын шийдвэрээр 27.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжин ирснийг санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүйгээр хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 16 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 2022 оны ажил үйлсээрээ аймгийн "тэргүүний байгууллага хамт олноор" шалгарсан.

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор ХХҮГазар нь "Халамжаас хөдөлмөрт" шилжих бодлогын хүрээнд аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхийн тоо өмнөх оноос 498 өрхөөр буюу 46.4 хувиар буурсан, "Аз жаргалтай гэр бүл III аян"-ыг зохион байгуулан 1 өрхийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлсэн, өрхийн амьжиргааны түвшинг тогтоох судалгаагаар Жаргалант, Мөст, Манхан, Дөргөн сумдад хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхүүдийг хамруулан нөхцөл байдлын үнэлгээ хийгдсэн байна.

021020100

Мөн Залуучуудын гарааны бизнес START UP буцалтгүй тусламж 3Д-ын А/61 тоот захирамжаар аймгийн ОНХС-аас 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЙДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,750,543.80	30,075,071.51
33	АВЛАГА	164,976.80	353,971.51
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	24,994.71
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	164,976.80	328,976.80
35	БАРАА МАТЕРИАЛ	29,585,567	29,721,100
351	Түүхий эд материал	76,500	76,500
35130	Эм боох материал	76,500	76,500
354	Хангамжийн материал	29,509,067	29,644,600
35410	Бичиг хэргийн материал	466,000	246,000
35420	Аж ахуйн материал	1,492,996	5,413,610
35430	Сэлбэг хэрэгсэл	2,448,000	-
35460	Хүнсний материал	21,987	-
35470	Бусад хангамжийн материал	25,080,084	23,984,990
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	800,079,763.97	784,407,296.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	800,079,763.97	784,407,296.23
392	Биет хөрөнгө	745,213,514.05	728,587,296.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	724,468,121	724,468,121
39202	Хуримтлагдсан элэгдэл	(81,556,042.29)	(99,900,172.26)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,000,000	115,463,480
39204	Хуримтлагдсан элэгдэл	(80,000,000)	(96,746,643.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	241,734,887.07	251,578,787.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(196,686,621.81)	(219,549,161.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	130,620,451.00	140,020,451.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(73,492,280.92)	(86,872,565.97)
39217	Ном	125,000	125,000
393	Биет бус хөрөнгө	54,866,249.92	55,819,999.80
39301	Програм хангамж	30,675,000	40,475,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(20,808,750.08)	(29,655,000.20)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,000,000	45,000,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	829,830,307.77	814,482,367.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	829,830,307.77	814,482,367.74
51	Засгийн газрын хувь оролцоо	829,830,307.77	814,482,367.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	216,668,324	216,668,324
51101	Өмч: - төрийн	216,668,324	216,668,324
512	Хуримтлагдсан үр дүн	591,235,744.53	575,887,804.50
51210	Өмнөх үеийн үр дүн	591,235,744.53	591,235,744.53
51220	Тайлант үеийн үр дүн	-	(15,347,940.03)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,926,239.24	21,926,239.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	829,830,307.77	814,482,367.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,018,583,608.32	916,477,606.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	207,625,799.32	126,837,006.78
120	Нийтлэг татварын бус орлого	207,625,799.32	126,837,006.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	207,625,799.32	126,837,006.78

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,576,161.32	74,428,000
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	150,049,638	52,409,006.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	810,957,809	789,640,600
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	799,136,100	744,288,600
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	799,136,100	744,288,600
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,735,000	45,352,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	735,000	70,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000	35,282,000
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	86,709	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	86,709	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	940,920,738.80	931,825,546.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	940,920,738.80	931,825,546.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	862,026,829.80	904,248,354.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	587,643,804.63	604,804,846.80
210101	Үндсэн цалин	587,643,804.63	589,772,846
210104	Урамшуулал	-	15,032,000
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,338,368.57	78,301,194.50
210201	Тэтгэврийн даатгал	67,837,414.24	54,837,994.50
210202	Тэтгэмжийн даатгал	3,039,574.84	5,865,800
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,431,659.07	4,692,600
210204	Ажилгүйдлийн даатгал	550,865.86	1,173,200
210205	Эрүүл мэндийн даатгал	6,478,854.56	11,731,600
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,225,900	40,033,650
210301	Гэрэл, цахилгаан	5,846,800	6,362,049
210302	Түлш, халаалт	26,073,201	26,073,201
210303	Цэвэр, бохир ус	7,305,899	7,598,400
2104	Хангамж, бараа материалын зардал	27,168,896.06	21,923,340
210401	Бичиг хэрэг	4,026,300	10,078,000
210402	Тээвэр, шатахуун	8,084,800	4,316,770
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,266,000	1,732,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	445,100	254,100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,346,696.06	5,541,670
2105	Нормативт зардал	26,304,085	36,348,434
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	636,200	763,197
210502	Хоол, хүнс	25,207,385	35,585,237
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	460,500	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,723,650	5,524,930
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,425,900	3,856,850
210604	Урсгал засвар	297,750	1,668,080
2107	Томилолт, зочны зардал	-	3,152,000
210702	Дотоод албан томилолт	-	3,152,000

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,589,779	50,726,755
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,913,379	48,760,655
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,440,000	725,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,000	378,200
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000	126,100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	539,400	442,600
210807	Газрын төлбөр	350,000	294,200
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,032,346.54	63,433,204.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,590,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,442,346.54	63,433,204.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,893,909	27,577,191.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,837,109	26,942,900
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	86,709	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,914,000	22,954,400
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	836,400	3,988,500
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,056,800	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,056,800	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	634,291.99
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	-	634,291.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>77,662,869.52</u>	<u>(15,347,940.03)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,933,038.60	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,933,038.60	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,933,038.60)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>75,729,830.92</u>	<u>(15,347,940.03)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>872,611,809</u>	<u>863,870,600</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>61,654,000</u>	<u>74,230,000</u>
120	Нийтлэг татварын бус орлого	61,654,000	74,230,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,576,161.32	74,230,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,576,161.32	74,230,000
120009	Бусад орлого	4,077,838.68	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>810,957,809</u>	<u>789,640,600</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	799,136,100	744,288,600
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	799,136,100	744,288,600
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,735,000	45,352,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	735,000	70,000

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000	35,282,000
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	86,709	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	86,709	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	872,611,809	863,870,600
21	УРСГАЛ ЗАРДАЛ	872,611,809	863,870,600
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	793,717,900	836,293,408.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590,659,200	608,383,858.01
210101	Үндсэн цалин	433,417,622.27	424,064,867.37
210102	Нэмэгдэл	139,569,457.72	124,266,974.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,672,120.01	26,543,477.19
210104	Урамшуулал	-	33,508,539.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,499,800	74,416,400
210201	Тэтгэврийн даатгал	55,611,000	50,953,200
210202	Тэтгэмжийн даатгал	5,722,200	5,865,800
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,577,800	4,692,600
210204	Ажилгүйдлийн даатгал	1,144,400	1,173,200
210205	Эрүүл мэндийн даатгал	11,444,400	11,731,600
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,225,900	40,033,650
210301	Гэрэл, цахилгаан	5,846,800	6,362,049
210302	Түлш, халаалт	26,073,201	26,073,201
210303	Цэвэр, бохир ус	7,305,899	7,598,400
2104	Хангамж, бараа материалын зардал	10,001,600	15,632,590
210401	Бичиг хэрэг	2,838,300	7,192,000
210402	Тээвэр, шатахуун	2,054,800	3,437,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,266,000	1,782,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	444,100	354,100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,398,400	2,866,690
2105	Нормативт зардал	26,564,921	34,189,397
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	636,200	763,197
210502	Хоол, хүнс	24,819,621	32,986,200
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,109,100	440,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,176,700	3,816,780
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,702,750	2,469,400
210604	Урсгал засвар	473,950	1,347,380
2107	Томилолт, зочны зардал	-	3,152,000
210702	Дотоод албан томилолт	-	3,152,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,589,779	56,668,733
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,913,379	54,702,633
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,000	-

210803	Даатгалын үйлчилгээ	1,440,000	725,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,000	378,200
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000	126,100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	539,400	442,600
210807	Газрын төлбөр	350,000	294,200
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,893,909	27,577,191.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,837,109	26,942,900
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	86,709	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,914,000	22,954,400
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	836,400	3,988,500
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,056,800	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,056,800	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	634,291.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	634,291.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,668,324	-	591,235,744.53	807,904,068.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	49,441,485	-	
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,668,324	21,926,239.24	591,235,744.53	829,830,307.77
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,668,324	21,926,239.24	591,235,744.53	829,830,307.77
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	216,668,324	21,926,239.24	591,235,744.53	829,830,307.77
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(15,347,940.03)	(15,347,940.03)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,668,324	21,926,239.24	575,887,804.50	814,482,367.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	819,889,800	817,884,308	2,005,492	100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	819,889,800	817,884,308	2,005,492	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	792,946,900	790,941,408	2,005,492	100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	592,320,500	592,102,858	217,642	100
210101	Үндсэн цалин	448,158,600	441,292,406	6,866,194	98
210102	Нэмэгдэл	121,604,100	124,266,974	(2,662,874)	102

210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,557,800	26,543,477	(3,985,677)	118
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,416,400	74,416,400	-	100
210201	Тэтгэврийн даатгал	50,953,200	50,953,200	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	5,865,800	5,865,800	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,692,600	4,692,600	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,173,200	1,173,200	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	11,731,600	11,731,600	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,350,300	40,033,650	316,650	99
210301	Гэрэл, цахилгаан	7,942,400	6,362,049	1,580,351	80
210302	Түлш, халаалт	26,075,300	26,073,201	2,099	100
210303	Цэвэр, бохир ус	6,332,600	7,598,400	(1,265,800)	120
2104	Хангамж, бараа материалын зардал	10,237,900	9,784,590	453,310	96
210401	Бичиг хэрэг	2,740,400	2,685,600	54,800	98
210402	Тээвэр, шатахуун	2,973,800	2,515,400	458,400	85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,362,800	1,362,800	-	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	354,100	354,100	-	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,806,800	2,866,690	(59,890)	102
2105	Нормативт зардал	34,866,200	34,189,397	676,803	98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,440,000	763,197	676,803	53
210502	Хоол, хүнс	32,986,200	32,986,200	-	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	440,000	440,000	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,096,500	3,816,780	279,720	93
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,469,400	2,469,400	-	100
210604	Урсгал засвар	1,627,100	1,347,380	279,720	83
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,659,100	36,597,733	61,367	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,693,000	34,631,633	61,367	100
210803	Даатгалын үйлчилгээ	725,000	725,000	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	378,200	378,200	-	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	126,100	126,100	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	442,600	442,600	-	100
210807	Газрын төлбөр	294,200	294,200	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,942,900	26,942,900	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,942,900	26,942,900	-	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,954,400	22,954,400	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,988,500	3,988,500	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	819,205,200	817,884,308	1,320,892	100
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	744,288,600	743,654,308	634,292	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	744,288,600	743,654,308	634,292	100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	74,916,600	74,230,000	686,600	99

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,916,600	74,230,000	686,600	99
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
610002	Төсвөөс гадуур байгууллага	1	1	-	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	51	50	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	41	40	-	100
620003	Үйлчлэх ажилтан	9	9	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,735,000	45,352,000
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,735,000	45,352,000
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,735,000	45,352,000
210104	Урамшуулал		16,281,000
2104	Хангамж, бараа материалын зардал		5,848,000
210401	Бичиг хэрэг		4,506,400
210402	Тээвэр, шатахуун		921,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		420,000
2107	Томилолт, зочны зардал		3,152,000
210702	Дотоод албан томилолт		3,152,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		20,071,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,735,000	20,071,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,735,000	45,352,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,735,000	45,352,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	735,000	70,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000	35,282,000

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь 2022 онд “Халамжаас хөдөлмөрт шилжих” бодлогын хүрээнд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг мэргэжил олгох сургалтад хамруулах, ажилд зуучлах, төсөл хөтөлбөр, санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжин тогтмол орлоготой болгох” гэсэн зорилтын хүрээнд Ховд аймгийн Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн

үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шуурхай хүргэх” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/274 тоот тушаалаар Ховд аймгийн Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын бүтэц, орон тоог 51 орон тоотойгоор баталж, захиргаа, хяналтын, нийгмийн халамжийн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сум хариуцсан мэргэжилтэн гэсэн 3 хэлтэстэй 50 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тус газар нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 16 зорилт, 65 арга хэмжээ, 6 чиглэлийн хүрээнд боловсруулж, 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, аймгийн Засаг даргаар хянуулан баталсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн халамжийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Шилэн дансны тухай хууль, Татвар, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн албаны тухай хууль тогтоомж, харьяа яамнаас гаргасан тушаал, шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдсан бусад мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ХХҮГазрын даргын тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг томилж байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж тайлант онд 10 ажлыг төлөвлөснөөс 9 ажлыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, 1 ажил буюу хөрөнгийн код шинэчлэх ажил түр хугацаагаар хойшлогдсон байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дэргэдэх дотоод хяналтын албанаас 2022 онд ХХҮГ-ын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний А/30 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулан ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.3 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.2	0.4	0.2
Бараа материал	29.6	29.7	0.1
Үндсэн хөрөнгө	800.0	784.4	(15.6)
Нийт хөрөнгө	829.8	814.5	(15.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	829.8	814.5	(15.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	829.8	814.5	(15.3)

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Авлага данстай холбоотой туслах үйл ажиллагааны орлогын 0.2, НДШ-ийн 0.2 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,066.1, төсөвт байгууллагын өөрийн орлого 74.9 сая төгрөг нийт 1,141.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 321.8 сая төгрөгөөр бууруулж, 819.2 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд анх батлагдсан 819.2 сая төгрөгийн төсвийг 2022 онд 3 удаа тодотгон баталж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 744.3 сая төгрөгийг улсын төсвөөс, туслах үйл ажиллагааны орлогоор 74.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 743.7 сая төгрөгийн санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлогоор 74.2 нийт 817.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 817.9 сая төгрөг буюу 99.8 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая. төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71902 - Нийгмийн халамж					
1	71902 /80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	599.6	599.0	0.6	99.9
2	71902 /80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	74.9	74.2	0.7	99.1
3	71902 /80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	26.9	26.9	-	100
72102 - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих					
1	72102 /80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	117.8	117.8	-	100
ДҮН		819.2	817.9	1.3	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Нийгмийн халамжийн сангаас Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд 7.0, амьжиргаа дэмжих зөвлөлийн урамшууллын зардалд 22.3, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны А/230 тоот захирамжаар Нийгмийн халамжийн сангаас хяналтын албан томилолт 2.0, маягт хэвлүүлэх зардалд 4.0, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гарааны бизнест /START-UP/ 10.0 сая төгрөг нийт 45.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-

ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 02 дугаар сарын 06-ноос 02 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 35 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 940.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 931.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.0 сая, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 10.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаагүй байна.

Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь энэ хуулийн, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 13 дугаар зүйлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан холбоотой заалтууд хамаарахгүй байна.

5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч даргын орон тоогоор хассантай холбоотой ХХҮЕГ-ын 01/732 тоот албан бичгээр 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор чөлөөлөхөөр шийдвэрлэж, 5 дугаар сард 1.1 сая төгрөгийн цалин олгосон.

6 дугаар зүйлд заасан шатахууны зардалд 2.9 сая төгрөг батлагдаж төсвийн хүрээнд зарцуулсан. Мөн нэмэлт дансаар өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа, амьжиргаа дэмжих зөвлөлийн хяналтын зардалд 1.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

9 дүгээр зүйлд зааснаар үйл ажиллагааны төсөвт албан томилолтын зардалд батлагдаагүй, нэмэлт санхүүжилтийн дансаар өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа, ХХҮЕГ-ын даргын тушаалаар дотоод хяналт үнэлгээгээр сумдад ажиллах томилолтын зардал 3.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд байгууллагын дотоод журам, ажилчдын хурлаар хэлэлцэн 3.8 сая төгрөгийн зардал гаргасан.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн зүйл худалдан авах зардалтай холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээ шаардлагагүй 0.4 сая төгрөгийн материал худалдан авсан.

15 дугаар зүйлд заасан бусад зардлын хувьд захиалагчийн хяналтын зардалд байгууллагын үйл ажиллагааны зардал, төсөл хөтөлбөр, албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт, тоног төхөөрөмж худалдан авах, Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн гишүүдийн цалинд 47.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийх алдаа¹ илрээгүй болно.

Харин цаашид засаж сайжруулах шаардлагатай нийт 3.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн зарлагын баримт, эд хариуцагчийн бараа материалын тайланд 0.2 сая төгрөгийн орлогыг зөрүүтэй авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

5.2.1 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хуулиар 2022 оны 5 сарын 1-ээс дэд даргын орон тоог цомхотгохоор заагдсан, ХХҮЕГ-ын даргын 01/732 тоот албан бичгээр 2022 оны 6 сарын 10-аас чөлөөлөх шийдвэрлэж 1.1 сая төгрөгийн цалингийн зардалд зарцуулсан.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах

5.2.2 Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХҮГ-ын дэргэдэх "Цагаан уул" ахмадын амралтад амарч байгаа амрагчийн хоногийн зардлыг 2019 онд 15.0 мянган төгрөгөөр тогтоосон, хөдөө орон нутагт өргөн хэрэглээний бараа материалын үнэ ханш нэмэгдэж, батлагдсан төсөв хүрэлцдэг, ажиллаж байгаа албан хаагчдын цалин, хоол хүнсний зардал дутагдалтай байна.

Өгсөн зөвлөмж: Дээд шатны байгууллагад уламжилж хоногт ноогдох зардлын хэмжээг нэмэгдүүлэх

5.2.3 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ТӨБЗГ-ын шийдвэрээр шилжин ирсэн тээврийн хэрэгсэл 2022 оны 11 дүгээр сард осолд орж гэмтсэн, хуулийн байгууллагын шийдвэр дүгнэлт гарсан ч тээврийн хэрэгслийг ашиглах боломжгүй байдалтай байгаа зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Тээврийн хэрэгслийн асуудлыг холбогдох хууль хяналтын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэн, хөрөнгийн ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлж ажиллах

5.2.4 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хуулиар нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас дотоод журамд заагдаагүй асуудлыг хамт олноор хэлэлцүүлэн 1.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Өгсөн зөвлөмж: Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс					
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн халамжийн сангаас 1 ор хоногийн хөнгөлөлтийг 15.0 мянган төгрөгөөр тооцон санхүүжилт олгогдог ч зах зээлийн үнийн өсөлттэй уялдаагүй, сувилалд ажиллаж байгаа ажилчдын цалин, хоол хүнс болон бусад зардалд хүрэлцдэггүй, үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлсэн	1	-			1	-

Хүнсний бараа материалын худалдан авалтын ебаримт, эд хариуцагчийн орлогын баримт зөрүүтэй бичсэн	1	0.2	1	0.2		-
Мэргэжлийн боловсрол сургалт үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвөөс 2022 оны 4 сард LAND 100 маркийн автомашиныг шилжүүлэн авсан, 11 дүгээр сард албаны ажлаар явж байгаад унаж тээврийн хэрэгсэл ашиглах боломжгүй болсон	1	-			1	-
Дүн	3	0.2	1	0.2	2	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая. төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил				
ХХҮЕГ-ын даргын 01/732 тоот албан бичгээр дэд даргын орон тоог 2022 оны 6 сарын 10-аас чөлөөлөх шийдвэр гаргасан	1	1.1	1	1.1
Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас дотоод журамд заагдаагүй асуудлыг хамт олноор хэлэлцүүлэн зарцуулсан	1	1.9	1	1.9
Дүн	2	3	2	3

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 06/A2160424

Ховд

ХОА-2022/05/НА/-СТА-ТШЗ
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд хүнсний материалын худалдан авалтын ебаримт, эд хариуцагчийн бараа материалын тайланд анхан шатны баримтыг 203450 төгрөгийн зөрүүтэй хүлээн авч зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д " төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 203450 /хоёр зуун гурван мянга дөрвөн зуун тавин төгрөг/-ийг эд хариуцагчаар төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Л.Билэгдэмбэрэл, нягтлан бодогч Х.Цэцэгбал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ